



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/83

Улаанбаатар хот

**Даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах
журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Байгууллагын даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/66 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журам-ын 2.5-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/148 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын Даргын дэргэдэх зөвлөлийн ажиллах журам”-д дор дурдсан хэсгийг нэмсүгэй.

Зургаа. Хуралдааны дэг

6.1.Зөвлөлийн нарийн бичиг нь хурлын ирц, хэлэлцэх асуудал, асуулт, хариулт, санал, шүүмж, түүний дараалал, хуралдааны дэгийн талаар зөвлөлийн гишүүд, хуралдаанд оролцогчдод урьдчилан танилцуулна.

6.2.Хуралдааны явцыг дуу, дуу дүрс бичигч төхөөрөмжөөр баримтжуулж болох бөгөөд үүнээс бусад зорилгоор дуу, дуу дүрс бичигч, гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж авч орох, утсаар ярихыг хориглоно.

6.3.Зөвлөлийн гишүүд, хуралдаанд оролцогч үг хэлэх, байр сууриа илэрхийлэх, тайлбар хийх, асуулт асуухдаа гараа өргөж, хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна.

6.4.Зөвлөлийн гишүүд, хуралдаанд оролцогч үг хэлэх, байр сууриа илэрхийлэх, тайлбар, танилцуулга хийх, асуулт асуухдаа босож зогсон санаагаа товч, тодорхой илэрхийлэх бөгөөд бүдүүлэг үг хэллэг хэрэглэхийг хориглоно.

6.5.Тодорхой асуудлын талаар санал хураалтыг гар өргөж явуулна. Санал хураалтын дүнг хуралдаан даргалагч дэмжсэн болон татгалзсан гишүүдийн тоо, нэрийг дурдаж, нэгтгэн танилцуулна. Санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

6.6.Зөвлөлийн гишүүд, хуралдаанд оролцогч нь ажил хэрэгч хувцаслах, зангиа зүүх болон албаны дүрэмт хувцсыг өмсөж, хуралдаанд хүндэтгэлтэй оролцоно.

6.7.Хуралдаан даргалагч хуралдааныг удирдаж, дэгийг сахиулна.

172200499

6.8.Хуралдааны дэг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газрын дарга (Д.Давааням)-д даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР